

**БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГАД НЭР ДЭВШҮҮЛЭХ
АСУУДЛААР ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2020 оны 7 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7, 17 дугаар зүйлийн 17.3.5 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг Байнгын хорооны 2020 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэнгийн Улсын Их Хуралд сонгогдон ажилласан туршлага, төрийн ажлын мэдлэг, ур чадварыг харгалзан Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны даргад нэр дэвшүүлснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэнг нэр дэвшүүлсэн тухай Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**



Ж.БАТЖАРГАЛ